



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

№ 306
танай _____ ны № _____ т

┌ РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА ┐
└ Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА ┘

Төрийн аудитын газраас танай байгууллагын 2022 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийсэн дүгнэлт, тайланг хүргүүлж байна.

Аудитаар 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага, 60,981.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор бүрэн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана уу.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭ



006030363



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Рашаант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/14/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Булган аймаг
2023 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Г.Цэрэнлхам
Утас: 7034-2495 Цахим хаяг: Tserenlhamg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө	10
3.4.2 Авлага	11
3.4.3 Бараа материал	12
3.4.6 Үндсэн хөрөнгө	12
3.4.7 Өр төлбөр	13
3.4.10 Засгийн газрын хувь оролцоо	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.7.1 Завсрын аудитын талаар	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	19
5.2 Албан шаардлага	20
5.3 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023-03-24 № 305

танай _____ ны № _____ т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Рашаант сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Рашаант сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн ажил гүйлгээг бүртгэхдээ цаг хугацааны дараалал болон арга хэмжээг санхүүжүүлсэн ажил гүйлгээ бүрээр журналд бүртгээгүй, зээл, зээлийн хүүгийн авлагыг богино болон урт хугацаат хөрөнгө оруулалтын дансанд ангилаагүй хууль журмыг хэрэгжүүлээгүй, Мөн Түшээт булаг ХХК-иас шатахууныг бичгээр худалдан авалт хийдэг гэх боловч и-баримтаар баталгаажуулаагүй, зарлагын баримт байхгүй, шатахуун зарцуулалтад жолоочийн тооцооны хуудас бодоогүй, ажил гүйцэтгэх гэрээ байхгүй ажилласан байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар", Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил үйлгээг, бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ыг баримтлаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

006020306

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг дарга сумын Засаг даргатай байгуулсан гэрээг дүгнүүлэн гүйцэтгэлийн үнэлгээгээр бусад сумдаа хошуучлан гутгаар байр эзэлсэн байна.

Аудитын гол асуудал

Шалгагдагч байгууллага нь 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд ирүүлээгүй тул тул хариуцлага тооцох албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүллээ.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад тусгай сангийн дансны бичилтийг НББББ-ыг мөрдөөгүй, авлагыг хугацаагаар нь богино болон урт хугацаат авлагаар ангилж, санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлээгүйгээс бодитой мэдээллээр хэрэглэгчдийг хангаж чадахгүй эрсдэл үүсэж байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



~~Б.ЭРДЭНЭ~~

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,175,349.40	613,608.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	533,825.10	444,918.00
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	268,566.20	104,687.90
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	372,958.10	64,002.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		7,593,406.70	1,791,445.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	7,593,406.70	1,791,445.60
39200	Биет хөрөнгө		7,513,849.90	1,776,732.20
39300	Биет бус хөрөнгө	13	79,556.80	14,713.50
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		8,768,756.10	2,405,054.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		61,539.20	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	61,539.20	-
41300	Өглөг	17а, 17б	61,539.20	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		8,707,216.90	2,405,054.00
51	Засгийн газрын хувь оролцоо		8,707,216.90	2,405,054.00
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,899,781.50	470,721.50
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		-	470,721.50
51200	Хуримтлагдсан үр дүн		2,473,379.50	1,049,042.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		4,334,055.80	885,290.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		8,768,756.10	2,405,054.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		6,374,115.60	1,814,600.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО		199,247.10	507,309.40
110	Орлогын албан татвар		112,594.40	409,536.50
1100	Хувь хүний орлогын албан татвар		112,594.40	409,536.50
113	Хөрөнгийн албан татвар		60,260.60	62,198.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж		26,392.20	35,574.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	2,995,392.00	466,456.20
120	Нийтлэг татварын бус орлого		2,995,392.00	466,456.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,179,476.60	840,834.90
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	3,891,372.20	1,715,870.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,891,372.20	1,715,870.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,711,062.20	1,312,543.90

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,754,530.80	359,977.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	230,745.50	43,528.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	561,170.20	572,307.70
2104	Хангамж, бараа материалын зардал	86,856.70	38,356.50
2105	Норматив зардал	431,437.40	800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,829.50	45,926.50
2107	Томилолт, зочны зардал	6,408.20	5,451.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,041.00	935.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	602,043.00	245,260.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	180,310.00	403,326.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,482,743.40	98,730.50
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,458.20	6,330,575.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,471,285.20	(6,231,844.50)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,604,709.00	1,567,102.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	199,247.10	507,309.40
110	Орлогын албан татвар	112,594.40	409,536.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	112,594.40	409,536.50
113	Хөрөнгийн албан татвар	60,260.60	62,198.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж	26,392.20	35,574.20
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,325.20	10,992.70
1181	Газрын төлбөр	14,807.00	22,122.50
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	3,260.00	2,459.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	335,223.10	218,958.20
120	Нийтлэг татварын бус орлого	335,223.10	218,958.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,070,238.80	840,834.90
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,252,688.40	1,198,229.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,252,688.40	1,198,229.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,060,470.80	1,189,173.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,736,414.60	360,919.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	232,381.20	44,285.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	561,170.20	572,307.70
2104	Хангамж, бараа материалын зардал	77,462.60	41,448.60
2105	Норматив зардал	220,636.50	800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,107.50	54,775.70
2107	Томилолт, зочны зардал	6,408.20	5,451.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,479.00	935.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	175,411.10	108,249.40

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	192,217.50	9,055.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	352,020.60	368,873.40
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	40,889.20	452,130.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	40,889.20	452,130.60
2200	Дотоод эх үүсвэрээр	40,889.20	452,130.60
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(40,889.20)	(452,130.60)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(6,102.00)	(5,650.00)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	6,102.00	5,650.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	305,029.50	(88,907.20)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	228,795.60	533,825.10
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	533,825.10	444,918.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,242,107.40	6,242,107.40
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(3,578.60)	(3,578.60)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,238,528.80	6,238,528.80
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(2,597.20)	(2,597.20)
9	Тайлант үеийн үр дүн	2,471,285.20	2,471,285.20
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,707,216.90	8,707,216.90
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,707,216.90	8,707,216.90
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(70,318.30)	(70,318.30)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,636,898.60	8,636,898.60
19	Тайлант үеийн үр дүн	(6,231,844.50)	(6,231,844.50)
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,405,054.00	2,405,054.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,891,736.60	1,625,590.95	266,145.65	85.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,253,070.10	1,235,794.65	17,275.45	98.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,244,056.90	1,226,781.45	17,275.45	98.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	371,240.00	360,919.45	10,320.55	97.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,026.20	44,285.91	740.29	98.4

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	572,163.30	569,639.27	2,524.03	99.6
2104	Хангамж, бараа материалын зардал	39,752.80	39,735.00	17.80	100.0
2105	Нормативт зардал	800.00	800.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	122,760.00	122,760.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	9,018.10	5,451.40	3,566.70	60.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	935.50	935.50	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,361.00	82,254.93	106.07	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,013.20	9,013.20	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,013.20	9,013.20	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	453,666.50	384,146.30	69,520.20	84.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	185,000.00	5,650.00	179,350.00	3.1
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,891,736.60	1,538,558.67	353,177.93	81.3
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,446,571.00	1,488,977.58	(42,406.58)	102.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	445,165.60	49,581.10	395,584.51	11.1
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	110.00	100.00	10.00	90.9
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	54	49	5	90.7
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	54	49	5	90.7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	30,418.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	30,418.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,376.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,668.40
2104	Хангамж, бараа материалын зардал	1,713.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,994.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42.18
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	42.18
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	27,708.12
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,708.12
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	(2,710.58)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,710.58

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Рашаант сум эрхэм зорилгоо “Төрийн албан хаагчийн нэр төр, ёс зүйг өндөрт өргөн, иргэдийн оролцоо, сэтгэл ханамжид тулгуурласан, ил тод, авлига, хүнд сурталгүй төрийн үйлчилгээг үзүүлэх, Засаг даргын Тамгын газрын ажилтан ажиллагсад гэдгээрээ бахархаж, эрхэлсэн ажилдаа эзний ёсоор хандан, цомхон, чадварлаг багаар ажиллахад бидний зорилго оршино” гэж тодорхойлжээ.

2022 онд “Эрч хүчтэй, бүтээлч сэтгэлгээтэй шинийг эрэлхийлсэн, чадварлаг эвсэг хам олон хөгжлийн хөтөч уриатай мэдлэг чадварт суурилсан, мэргэшсэн захиргааны байгууллага болох” зорилтыг дэвшүүлэн, үйл ажиллагааны чиглэлээ дараа байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хууль тогтоомж, хөгжлийн бодлого, стратеги зорилт, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хяналт тавих,
- Төрийн албаны хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж мэргэшсэн тогтвортой чадварлаг төрийн албыг бий болгох
- Байгууллагын төсвийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнах, хяналт тавих ажлыг сайжруулж төсвийн тэнцлийг хангаж ажиллах,
- Батлах хамгаалах болон гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах,
- Хууль, эрх зүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шуурхай зохион байгуулж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх,
- Хэвлэл мэдээллийн ажлыг шинэ шатанд гаргаж иргэдэд үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь шуурхай хүргэж ажиллах,
- Аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам”, сумын Засаг даргын “Рашаант-Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (4 удаа),
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолд оруулсан нэмэлт өөрчлөлт,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Санхүүгийн хяналт аудитын алба 2022 онд Рашаант сумын Засаг даргын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгээгүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Рашаант сумын Засаг дарга нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Рашаант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр тушаалаар батлагдсан бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2,405,054.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,363,702.1 мянган төгрөгөөр буюу 72.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	533,825.10	444,918.00	(88,907.10)
Авлага	268,566.20	104,687.90	(163,878.30)
Бараа материал	372,958.10	64,002.50	(308,955.60)
Үндсэн хөрөнгө	7,593,406.70	1,791,445.60	(5,801,961.10)
Нийт хөрөнгө	8,768,756.10	2,405,054.00	(6,363,702.10)
Өр төлбөр	61,539.20	-	(61,539.20)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,707,216.90	2,405,054.00	(6,302,162.90)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,768,756.10	2,405,054.00	(6,363,702.10)

Дээрх хүснэгтээс харахад санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс нөлөө бүхий буюу материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Материаллаг өөрчлөлт гарсан нь Монгол Улсын засгийн газрын 2022 оны 131 дүгээр тогтоолоор сургуулийн өмнөх боловсролын өмнөх болон бага дунд боловсролын боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч нь Боловсролын ерөнхий газрын дарга байхаар батлагдсан, Мөн 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн “төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Төсвийн тухай хуульд өөрчлөлт орсноос нөлөөлсөн байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагч аймгийн Засаг дарга байсныг Төсвийн тухай хуулийн 2022 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн өөрчлөлтөөр хүчингүй болгосонтой холбоотой байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны оны эхний үлдэгдэл 533,825.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 444,918.0 мянган төгрөг болж, 88,906.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	531,114.00	444,918.0	(86,196.00)	100.0
Нэмэлт санхүүжилтийн харилцах	2,710.60	-	(2,710.60)	-
Арилжааны банк дахь харилцах	0.50	-	-	-
Дүн	533,825.10	444,918.00	(88,906.60)	100.0

Эх сурвалж: Рашаант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 9,976.2 мянган төгрөг буюу 2.2 хувийг Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, 168,907.2 мянган төгрөг буюу 38.0 хувийг Хоршоо хөгжүүлэх сан, 262,418.5 мянган төгрөг буюу 59.0 хувийг Орон нутгийн ерөнхий орлого, 3,616.1 мянган төгрөг буюу 0.8 хувийг Орон нутгийн хөгжлийн сан тус тус эзэлж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны оны эхний үлдэгдэл 268,566.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 104,687.9 мянган төгрөг болж, 163,878.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3. Авлагын дансны үлдэгдэл (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчтай холбогдсон авлага	1,733.20	1,588.80	(144.40)	1.5
Төлбөртэй үйлчилгээний авлага	114,796.50	-	(114,796.50)	-
Байгууллагаас авах авлага	15,494.40	1,200.00	(14,294.40)	1.1
Хувь хүмүүсээс авах авлага	136,542.10	101,899.10	(34,643.00)	97.3
Дүн	268,566.20	104,687.90	(163,878.30)	100.0

Эх сурвалж: Рашаант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 22,425.8 мянган төгрөг буюу 21.4 хувийг Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, 1,341.2 мянган төгрөг буюу 1.4 хувийг Иргэдийн төлөөлөгчдийн хурал, 1,447.6 мянган төгрөг буюу 1.4 хувийг ЗДТГ, 1,341.2 мянган төгрөг буюу 75.9 хувийг Хоршоо хөгжүүлэх сан тус тус эзэлж байна.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилж данс эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

3.4.4 Бараа материал

Бараа материал дансны оны эхний үлдэгдэл 372,958.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 64,002.5 мянган төгрөг болж, 275,965.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5. Бараа материал дансны үлдэгдэл (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Эм боох материал	39,671.30	-	(39,671.30)	-
Бичиг хэргийн материал	619.8	262.9	(356.90)	0.4
Аж ахуйн материал	255,790.00	63,739.60	(192,050.40)	99.6
Түлш, шатах тослох материал	1,821.30		(1,821.30)	-
Хүнсний материал	32,989.90			-
Бусад хангамжийн материал	42,065.80		(42,065.80)	-
Дүн	372,958.10	64,002.50	(275,965.70)	100.0

Эх сурвалж: Рашаант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 54,177.3 мянган төгрөг буюу 84.6 хувийг ЗДТГ, 9,825.2 мянган төгрөг буюу 15.4 хувийг Иргэдийн төлөөлөгчдийн хурал тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- ИТХурал 35410 дансанд бүртгэлтэй оны эхний зарцуулаагүй үлдэгдэл болох 11 ширхэг бичгийн цаас, 5 ширхэг А4 дуугуй, 6 ширхэг цавуу тайлагнагдсан боловч складад байхгүй байгаа нь агуулахын бүртгэл хөтлөөгүй,
- Бараа материалын тайлангийн 35420 дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай 7 нэр төрлийн нимгэн зурагт, өнгөт канон, скайнертай канон, систем хөгжим, ширээний микрофон, сейф, принтер зэрэг хөрөнгүүд бүртгэж тайлагнасан.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны оны эхний үлдэгдэл 7,593,406.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1,791,445.6 мянган төгрөг болж, 5,801,961.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Барилга, байгууламж, орон сууц	7,469,311.40	1,537,163.50	(5,932,147.90)	85.8
Хуримтлагдсан элэгдэл	(772,846.90)	(424,025.60)	348,821.30	(23.7)
Авто-тээврийн хэрэгсэл	326,077.00	210,678.00	(115,399.00)	11.8
Хуримтлагдсан элэгдэл	(264,299.60)	(117,627.60)	146,672.00	(6.6)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	657,157.70	232,235.80	(424,921.90)	13.0
Хуримтлагдсан элэгдэл	(357,254.20)	(74,262.60)	282,991.60	(4.1)
Тавилга, аж ахуйн эд хогшил	183,570.20	28,606.80	(154,963.40)	1.6
Хуримтлагдсан элэгдэл	(58,240.00)	(11,486.20)	46,753.80	(0.6)
Ном	32,024.90	-	(32,024.90)	-
Бусад үндсэн хөрөнгө	517,120.60	645,921.90	128,801.30	36.1
Хуримтлагдсан элэгдэл	(218,771.20)	(250,471.90)	(31,700.70)	(14.0)
Программ хангамж	8,900.00	3,850.00	(5,050.00)	0.2
Хуримтлагдсан элэгдэл	(3,131.20)	(3,212.50)	(81.30)	(0.2)
Бусад биет бус хөрөнгө	73,788.00	14,076.00	(59,712.00)	0.8
Дүн	7,593,406.70	1,791,445.60	(5,801,961.10)	100.0

Эх сурвалж: Рашаант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 1,776,002.0 мянган төгрөг буюу 99.1 хувийг ЗДТГ, 15,443.6 мянган төгрөг буюу 0.9 хувийг Иргэдийн төлөөлөгчдийн хурал эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- ИТХурал өмч хамгаалах байнгын зөвлөлийн хийсэн ажлын тайлан, гаргасан шийдвэр, хурлын тэмдэглэл байхгүй байна. Зөвхөн ИТХ-ын хуралдааны тогтоолоор хөрөнгө хасах шийдвэрийг гаргасан байна. Үлдэх өртөг 0 үлдэгдэлтэй 4 нэр төрлийн хөрөнгө байна. Мөн 21 хөрөнгийн кодтой 500.0 мянган төгрөгийн өртөгтэй 20 жил ашиглах төмөр сэйф, 10 ашиглах хугацаатай тавилга эд хогшлыг бүртгэж тайлагнасан.

3.4.7 Өр төлбөр

Өр төлбөр дансны оны эхний үлдэгдэл 61,539.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэлгүй болж, 61,539.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	16,994.60		(16,994.60)	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	13,000.90		(13,000.90)	-
Байгууллагад төлөх өглөг	31,543.70		(31,543.70)	-
Дүн	61,539.20		- (61,539.20)	-

Эх сурвалж: Рашаант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.4.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 8,707,216.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 2,405,054.0 мянган төгрөг болж, 6,302,162.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №8. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,899,781.50	470,721.50	(1,429,060.00)	19.6
Хуримтлагдсан үр дүн	2,473,379.50	1,049,042.50	(1,424,337.00)	43.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,334,055.90	885,290.00	(3,448,765.90)	36.8
Дүн	8,707,216.90	2,405,054.00	(6,302,162.90)	100.00

Эх сурвалж: Рашаант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны орон нутгийн оруулсан капитал дансны үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 3,073.5 мянган төгрөг буюу 0.6 хувь, 467,647.9 мянган төгрөг буюу 99.4 хувийг Засаг даргын тамгын газар тус тус эзэлж байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Орон нутгийн төсвийн орлогыг оны эхний үлдэгдлээс 60,000.0 мянга, татварын орлогоос 553,826.7 мянга, татварын бус орлогоос 94,648.0 мянган төгрөг нийт 708,474.7 мянган төгрөгөөр сумын ИТХ-д өргөн барьсан байна.

Өргөн барьсан төсвийг орон нутгийн төсвийн орлогыг 376,011.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, Сумын ИТХ-ын 2022 оны V/09 хуралдаанаар урсгал орлогыг 1,084,486.3 мянга, хөрөнгийн орлогыг 303,716.7 мянга, санхүүгийн дэмжлэгийг 982,115.0 мянга, тусгай сангийн орлогыг 162,401.0 мянга, өмнөх оны эхний үлдэгдлээс 323,118.7 мянган төгрөг нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,855,904.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг тодотголоор 239,801.5 мянган төгрөгөөр бууруулсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийн 27 арга хэмжээг санхүүжүүлэхээр 926,774.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогоос, 277,399.3 мянган төгрөгийг хөрөнгийн орлогоос, 721,962.9 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс бүрдүүлэхээр байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,891,736.6 мянган төгрөг буюу 85.9 хувьтай байгаа Иргэдийн хурлын дарга 679.0 мянга, Засаг дарга 195,946.0 мянга, орон нутгийн өмчийн байр арчилгаа, хамгаалалт, засвар үйлчилгээний төлбөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 0.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 7. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл (мянган төгрөгөөр)

Д/д	Хөтөлбөр арга хэмжээний нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	100,446.9	99,767.9	679.0	99.3
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	787,035.3	591,089.3	195,946.0	75.1
3	Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх хөрөнгө оруулалт	453,666.5	384,146.3	69,520.2	84.7
4	Ерөнхий боловсрол	343,680.1	343,680.0	0.1	100.0
5	Сургуулийн өмнөх боловсрол	95,163.6	95,163.5	0.1	100.0
6	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	69,070.7	69,070.6	0.1	100.0
7	Соёл урлаг	42,673.5	42,673.4	0.1	100.0
Нийт дүн		1,891,736.6	1,625,591.0	266,145.6	85.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын илрүүлэлт:

- ИТХурал, Засаг даргын тамгын газар тооцоолсон цалингаар цалингийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардлаар НДШ, ХХОАТ, бусад өглөгийг бүртгэсэн,

- ИТХурал, Засаг даргын тамгын газар Түшээт булаг ХХК-иас шатахууныг бичгээр худалдан авалт хийдэг гэх боловч и-баримтаар баталгаажуулаагүй, зарлагын баримт байхгүй, шатахуун зарцуулалтад жолоочийн тооцооны хуудас бодоогүй, ажил гүйцэтгэх гэрээ байхгүй,
- Орон нутгийн хөгжлийн сангийн гүйлгээг бүртгэхдээ цаг хугацааны дараалал болон арга хэмжээг санхүүжүүлсэн ажил гүйлгээ бүрээр журналд бүртгэхгүй бөөн дүнгээр нь дансны бичилт хийж бүртгэсэн,
- Хоршоо хөгжүүлэх сангийн ажил гүйлгээг бүртгэхдээ зээл, зээлийн хүүгийн авлагыг богино болон урт хугацаат хөрөнгө оруулалтын дансанд ангилаагүй, хууль журмыг хэрэгжүүлээгүй бөөн дүнгээр нь дансны авлага дансаар санхүүгийн тайланг бэлтгэсэн.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 197,848.4 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч эдийн засгийн ангиллын дагуу зарцуулалтын эрх нээлгэн зарцуулсан байна. Нэмэлт орлогын эх үүсвэрийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 8. Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалт (мянган төгрөг)

№	Эх үүсвэр, зориулалт	Мөнгөн дүн
1	Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газраас улсын тэргүүний сумын шагналд	100,000.0
2	Аймгийн ИТХ-аас сумын ИТХ-ын байгууллага дүгнэсэн шагнал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн зардалд	2,550.7
3	Эрүүл мэндийн төвийн өмнөх оны нэмэлт харилцахын үлдэгдэлд	4,561.3
4	Аймгийн Статистикийн хэлтсээс хөдөө аж ахуйн тооллогын зардал, багийн засаг дарга нарт сурталчилгааны зардалд, ХАА-н ээлжит тооллогын зардалд	5,324.6
5	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх зардалд, морин эргүүлийн урамшуулалд, отоглох цэг байгуулах зардалд, гамшгийн эрсдэлээс бууруулах зардалд, байгалийн гамшгийн эрсдэлээс бууруулах арга хэмжээний зардалд, цэвэр орчин цэмцгэр булган аяны зардалд, Ойн арчилгааны зардалд	40,260.4
6	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ЗДТГ-ын их засварын зураг төсвийн зардал, эрэн хайх аврах бүлгийн байрны засварын зардалд	36,896.2
7	Аймгийн Засаг даргын тамгын газраас аймгийн Засаг даргын А/57 дугаар захирамжаар хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр 1-р байр эзэлсэн шагналд	4,385.0
8	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	3,871.0
Нийт дүн		197,848.4

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Рашаант сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн орон нутгийн төсвийн орлого, шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цэрэнлхам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Рашаант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр албан бичиггүй ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь сумын ИТХ-ын хуралдаанаар батлагдсан нийт орлого ба тусламж санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт орлого ба тусламж санхүүжилт 2,616,169.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 39,242.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 29,431.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Мөн хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Хуулийн 20 дугаар зүйлийн тайлагнал, ил тод байдлын 20.5-д заасан этгээд шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг сумын ЗДТГазар 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 154 мэдээлэл мэдээлэхээс сумын ЗДТГазар 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй болно.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2022 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 1-2/276 дугаар албан тоотоор ирүүлсэн.

Хүснэгт 9. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	184,629.8	2	-	66.7
Зөвлөмж	2	-	2	-	100.0
Нийт дүн	5	184,629.8	4	-	80.0

Орон нутгийн хөгжлийн сан, Хоршоо хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудлаар өгсөн албан шаардлагыг биелүүлдээгүй байна.

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын гүйцэтгэх цаг хугацааны нөөц, цар хүрээ хязгаарлагдмал байсан учраас дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлийг Орон нутгийн өмчийн газарт бүртгэлтэй хөрөнгөтэй тулгах, хөрөнгийн үлдэгдэлд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 60,981.5 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрснээс, 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, 60,981.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

1. Шалгагдагч байгууллага нь 2023 оны 03 дугаар сарын 05-ны өдөр санхүүгийн нэгтгэсэн тайлангаа ирүүлэх байтал хугацаа хоцроож 2023 оны санхүүгийн тайлангаа Төрийн аудитын газарт албан тоотгүй ирүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д "төсвийн төвлөрүүлэн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх" заалтыг хэрэгжүүлээгүй, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй, цагалбарт хугацаанд санхүүгийн тайлангаа Төрийн аудитын газарт ирүүлээгүй тул эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад хөрөнгө оруулалтыг бүртгэл тайлагналд тусгахдаа тухайн ажлын гэрээний гүйцэтгэлийн дүнгээр бүртгэлд тусгахгүй, бараа материалын нэр төрөл тус бүрээр орлогодуулахаар захирамж гаргасан.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажил, үйлчилгээ, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг гэрээний гүйцэтгэлийн дүнгээр бүртгэл тайланд тусгахаар Засаг даргын захирамж гаргаж ажиллах.

2. Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал

Илрүүлэлт: Рашаант сумын Засаг даргын 2 мэдээлэл, ИТХ 1 мэдээлэл тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах

3. Орлогын данстай холбоотой асуудал

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Малд ногдуулах орлогын албан татварыг 60,981.5 мянган төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн Рашаант сумын ИТХ-н 2021 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн 04 дүгээр тогтоолтой тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд нөөц бололцоогоо дайчлан ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ТТЗ												
ТШЗ	2	53.1			2	53.1	2	53.1				
Дүн	2	53.1			2	53.1	2	53.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	3	60.9	-	-			2	60.9	1	1		
ТШЗ	7	283.3			5	277.6	2	5.7				
Дүн	11	344.2	4	60.9	3	277.6	3	5.7	1	1		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТТЗ	1				-	-	1	
ТШЗ								
Дүн	1				-	-	1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ТТЗ								
ТШЗ								

Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	1				-	-	1	

